



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 225 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны албан ажлын хэрэгцээнд зориулан үйл ажиллагааны давсан орлогын эх үүсвэрээр 91,110,000.00 (ерэн нэгэн сая нэг зуун арван мянган) төгрөгт багтаан 1 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ



13201091

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дугаар сарын 22-ны өдрийн
1 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1999 сс хүртэл (чанга яригч бүхий тусгай дуут гэрлэн дохио, холбооны станц бүхий)	1	91,110,000.00	91,110,000.00
	Нийт дүн			91,110,000.00 (ерэн нэгэн сая нэг зуун арван мянган)